



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар

1105

Мандалговь


Үржлийн малд үзлэг ангилалт хийж
Малын генетик нөөцийн төлөв байдлыг
тодорхойлох ажлыг гүйцэтгэх аж ахуй
нэгжийн хуваарь батлах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.6, 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн А/36 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Үржлийн малд үзлэг, ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох гүйцэтгэх ажлыг хавсралтад заасан мэргэжлийн аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлсүгэй.

2. “Баталгаажсан үүлдэр омгийн малд үзлэг ангилалт хийж, генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлж, үнэлгээ хийх удирдамж”-ийн дагуу орон нутагт зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Үржлийн малд үзлэг, ангилалт хийж малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажлыг гэрээнд заасан хугацаанд чанартай явуулж мэдээ судалгаа, акт, санхүүгийн баримтыг бүрдүүлж үзлэг ангилалтын материалыг эцэслэн боловсруулж гарын үсэг зурж баталгаажуулж зохих газарт хүргэхийг Мал үржлийн албаны дарга (Ж.Батбилэг)-т даалгасугай.

ДАРГА  Б.МӨНХЖАРГАЛ



000001018